

БАТЛАВ.

АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ  
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГА




Ж.ЦОЛМОН

ШИНЖЛЭН ШАЛГАГЧ, ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ, ЗӨВЛӨХ,  
АЖИГЛАГЧ НАРЫГ СОНГОХ, ТОМИЛОХ ЖУРАМ

Баримт бичгийн код	АХОЗШША - 25-03		
Баталсан огноо:	2025 он- 10 сар- 30 өдөр		
Хянасан:	Албан тушаал, нэр Х.Наранхүү	Огноо 2025.10.29	Гарын үсэг 
Боловсруулсан:	Албан тушаал, нэр П.Бүрэнхүү	Огноо 2025.10.29	Гарын үсэг 

Өөрчлөлтийн бүртгэл

Өөрчлөлтийн дугаар	Өөрчлөлтийн товч тайлбар	Өөрчлөлт оруулах хэсэг	Өөрчлөлт хийсэн ажилтны нэр, албан тушаал	Огноо	Гарын үсэг
1	Мурлы, дурт	Бүтэц	и/и	2025. 10.24	

Түгээлтийн жагсаалт

№	Баримт бичиг	Хэнд (түгээх нэгж/байгууллага)
1	Мурлы	и/и нэрт
2		
3		

ШИНЖЛЭН ШАЛГАГЧ, ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ, ЗӨВЛӨХ,  
АЖИГЛАГЧ НАРЫГ СОНГОХ, ТОМИЛОХ ЖУРАМ

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Энэхүү журмаар Чикагогийн конвенцын Хавсралт-13-ын 5.1, 5.19-5.24 дэх заалт, Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны дүрэм"-ийн дагуу Монгол улс болон гадаад улсын нутаг дэвсгэрт гарсан Монгол улсад бүртгэлтэй, Монгол улсын тээвэрлэгчийн болон Монгол улсын иргэн өртсөн иргэний агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах үйл ажиллагаанд Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба (цаашид АХОЗШША гэх)-аас шинжлэн шалгагч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, зөвлөх, ажиглагч томилох, оролцуулах, мөн гадаад улсын шинжлэн шалгах байгууллага, мэргэжлийн байгууллагаас шинжлэн шалгагч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, зөвлөх, ажиглагч оролцуулах асуудлыг зохицуулна.

**ХОЁР. ШИНЖЛЭН ШАЛГАГЧ, ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ,  
ЗӨВЛӨХ, АЖИГЛАГЧ ТОМИЛОХ**

2.1. Агаарын хөлгийн осол, зөрчлийн талаарх мэдээллийг авсан АХОЗШША-ны жижүүрийн ажилтан нь албаны дарга бөгөөд ерөнхий шинжлэн шалгагчид танилцуулж, шинжлэн шалгах ажиллагаанд оролцох эсэх, шинжлэн шалгагч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, зөвлөх хэрхэн ажиллуулах талаар шийдвэр гаргуулж, осол, зөрчлийн газарт ажиллах шинжлэн шалгагчид яаралтай мэдэгдэнэ.

2.2. Агаарын хөлгийн осол, зөрчлийг зөвхөн мэргэшсэн шинжлэн шалгагчид гүйцэтгэх ёстой тусгай ажил юм. АХОЗШША нь шинжлэн шалгагчдыг нисэхийн салбарт ажилласан дадлага туршлагатай, ур чадвартай хүмүүсээс сонгон томилно. ICAO-ийн "Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах бодлого журмын гарын авлага" (Doc9962) баримт бичгийн 4-р бүлгийн 4.2 "Шинжлэн шалгагчдыг сонгох, томилох"-т заасан удирдамжийг мөрдлөг болгоно.

2.3. АХОЗШША нь бусад улсын агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах байгууллагуудтай түргэн хугацаанд, албан ёсны гэрээ, хэлэлцээргүйгээр тусламж авах, хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан байх ёстой.

2.4. АХОЗШША нь удирдлагын төлөвлөгөөнийхөө нэг хэсэг болгон үндсэн албан тушаалд томилогдсон мэргэшсэн шинжлэн шалгагчдын бүртгэлтэй, түүнчлэн тухайн улсын бусад байгууллагуудаас шаардлагатай дэмжлэг үзүүлэх мэргэжилтнүүдийг богино хугацаанд ажилд авах зохих зохицуулалтыг хийх боломжтой эсэхийг баталгаажуулсан байх ёстой.

2.5. Гаднын байгууллагын мэргэжлийн ур чадварыг ашиглахдаа шинжлэн шалгах ажиллагаанд оролцогчдын ажил үүргээс чөлөөлөх заалтуудыг багтаасан бичгээр байгуулсан гэрээ эсвэл хамтран ажиллах санамж бичгийн тусламжтайгаар хийдэг. Шинжлэн шалгах ажиллагаанд тэдний бие даасан, бодитой байдал чухал бөгөөд ашиг сонирхлын зөрчил байхгүй эсэхийг баталгаажуулах нь чухал юм.

2.6. Ослыг шинжлэн шалгах ажиллагаанд томилогдсон шинжлэн шалгагч бүр, түр хугацаагаар ажиллаж буй гаднын итгэмжлэгдсэн төлөөлөгч, зөвлөх, ажиглагч зэрэг албан тушаалтан бүр өөрийн үүрэг, хариуцлагын хүрээг бүрэн ойлгосон байх ёстой.

2.7. АХОЗШША-ны дарга бөгөөд ерөнхий шинжлэн шалгагч нь гадаад улсад болсон осол, зөрчлийн шинжлэн шалгах үйл ажиллагаанд итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцуулахаар шийдвэрлэсэн тохиолдолд тухайн улсад мэдэгдэнэ.

2.8. АХОЗШША нь шинжлэн шалгах ажлыг гүйцэтгэж байгаа улсад агаарын хөлөг, нисэх баг, ачааллын болон бусад мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар бэлтгэж хүргүүлэх ба энэ ажлыг тусгайлан томилогдсон шинжлэн шалгагч нар хариуцан гүйцэтгэнэ.

2.9. АХОЗШША өөр байгууллагаас итгэмжлэгдсэн төлөөлөгч томилж ажиллуулах тохиолдолд түүнийг үндсэн ажлаас чөлөөлөх, байр, унаа, томилолтын зардлын асуудлыг зохицуулсан байна.

2.10. Монгол улсын нутаг дэвсгэрт гарсан осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд “Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны дүрэм”-ийн дагуу гаднын улсаас болон бусад холбогдох байгууллагаас итгэмжлэгдсэн төлөөлөгч, зөвлөх, ажиглагч урьж ажиллуулна.

2.11. Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь шинжлэн шалгах ажиллагааны явц, нөхцөл, байдлаас шалтгаалж нарийн мэргэжлийн зөвлөх авах асуудлаар албаны дарга бөгөөд ерөнхий шинжлэн шалгагчид хүсэлт гаргаж болно. Албаны дарга бөгөөд ерөнхий шинжлэн шалгагч итгэмжлэгдсэн төлөөлөгч тусламж авах зорилгоор зөвлөх нэмж ажиллуулах асуудлаар хүсэлт гаргасан тохиолдолд холбогдох арга хэмжээг авна. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн шинжлэн шалгах ажиллагаанд туслах зорилгоор нэг буюу хэд хэдэн зөвлөхийг томилж болно.

2.12. Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь шинжлэн шалгах үйл ажиллагаанд оролцохдоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа олон улсын стандарт, зөвлөмж, баримт бичиг болон хууль, тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

2.13. Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь өөрийн зөвлөх, туслахын хөдөлмөр хамгааллын аюулгүй байдлыг хангах арга хэмжээг урьдчилан судалж мэдсэн, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авсан байна.

2.14. Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь осол, зөрчлийн талаар судалгаа, шинжилгээний ажлыг шинжлэн шалгах багийн ахлагчийн удирдлагын дор явуулж, зөвлөхүүдээ ямар чиглэлээр ажиллуулах талаар шийдвэр гаргаж байна. Зөвлөхүүд итгэмжлэгдсэн төлөөлөгчийн өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэхийн тулд идэвх чармайлт гарган ажиллана. Шинжлэн шалгах ажлын эхэн дунд төгсгөлийн шатанд өөрийн дүгнэлт гаргаж, шинжлэн шалгах ажиллагаа явуулж байгаа багийн ахлагчид танилцуулж, хэрвээ багийн ахлагч шаардлагатай гэж үзвэл багийн хуралд танилцуулж болно. Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь албаны дарга бөгөөд ерөнхий шинжлэн шалгагчтай байнгын холбоотой байж, өөрийн дүгнэлт, шинжлэн шалгах ажлын явцын талаар тогтмол танилцуулж байна.

2.15. Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь шинжлэн шалгах үйл ажиллагааны явцад олж авсан аливаа мэдээллийг шинжлэн шалгах ажиллагаа явуулж байгаа улс орны зөвшөөрөлгүйгээр тараах, хэвлэн нийтэх болон бусад хэлбэрээр тайланд нэвтрэхээс хамгаалах арга хэмжээ авна. Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь шинжлэн

шалгах ажиллагааны төгсгөлд ажлынхаа тайланг албан дарга бөгөөд ерөнхий шинжлэн шалгагчид танилцуулсны дараа шинжлэн шалгах ажиллагаа явуулсан багийн ахлагчид өөрийн санал дүгнэлтийг илгээнэ. Уг санал, дүгнэлтийг эцсийн тайланд хавсаргах эсэхийг шинжлэн шалгах ажиллагаа явуулсан багийн ахлагч шийдвэрлэнэ.

2.16. АХОЗШША өөрийн шинжлэн шалгах үйл ажиллагааны болон орон нутгийн онцлогийг итгэмжлэгдсэн төлөөлөгч, зөвлөхөд танилцуулж, тэдэнтэй “нууц үл задруулах тухай” гэрээ байгуулна

2.17. Осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчид, зөвлөх, ажиглагч оролцуулах асуудлыг АХОЗШША-ны дарга бөгөөд ерөнхий шинжээчийн шийвэрээр зохицуулах ба үйл ажиллагааны хүрээ нь дараах байдлаар зохицуулагдана.

2.17.1. Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь “Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны дүрэм”-ийн 4.13 дугаар заалт;

2.17.2. Зөвлөх нь “Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны дүрэм”-ийн 4.14 дугаар заалт;

2.17.3. Ажиглагч нь “Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны дүрэм”-ийн 4.15 дугаар заалт;

2.17.4. Оролцогч нь “Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны дүрэм”-ийн 4.16 дугаар заалт;

## ГУРАВ. ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧДОД ИТГЭМЖЛЭЛ ҮНЭМЛЭХ ОЛГОХ

3.1. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд оролцож буй шинжлэн шалгагч, гадаад улсаас болон дотоодын бусад байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчид, зөвлөх, ажиглагч нарт итгэмжлэл олгох ажиллагааг АХОЗШША-аас зохих хууль журмын дагуу зохион байгуулж, хамтран ажиллах, нууц үл задруулах талаар гэрээ байгуулж шийдвэрлэнэ. Гэрээний загварыг Хавсралт 1-д үзүүлэв.

3.2. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд оролцох шинжлэн шалгагч, итгэмжлэгдсэн төлөөлөгчид, зөвлөх, ажиглагч нарт ослын газар, барилга байгууламж, тоног төхөөрөмж, баримт бичигт саадгүй нэвтрэх эрхтэй үнэмлэх олгоно.

3.2.1. АХОЗШША-ны орон тооны шинжлэн шалгагчид Засгийн газраас баталгаажуулсан үнэмлэхтэй байна. Тухайн үнэмлэх дээр эзэмшигчийн фото зураг, үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн үндсийг тодорхой тусгасан байна. Шинжлэн шалгагч нар хил, гаалиар нэвтрэх, саадгүй хурдан шуурхай үйл ажиллагаа явуулах зорилгоор албан паспорттай байх нь үйл ажиллагааг хялбарчлахад тустай байдаг.

3.2.2. Шинжлэн шалгах ажиллагаанд гадаад улсаас оролцож буй итгэмжлэгдсэн төлөөлөгчид, зөвлөх, ажиглагч нарт ослын газар, барилга байгууламж, тоног төхөөрөмж, баримт бичигт саадгүй нэвтрэх эрхтэй түр үнэмлэх олгоно. Тухайн үнэмлэх дээр эзэмшигчийн фото зураг, үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн үндсийг тодорхой тусгасан, эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан байна.

3.2.3. Шинжлэн шалгах ажиллагаанд оролцох орон тооны бус шинжлэн шалгагч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, зөвлөх, мэргэжилтнүүдэд ослын газар, барилга байгууламж, тоног төхөөрөмж, баримт бичигт нэвтрэх эрхтэй, үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн үндэс, эрх, үүргийг тодорхой тусгасан түр үнэмлэх олгоно. Үнэмлэхийн загваруудыг Хавсралт 2-д үзүүлэв.

3.2.4. Осол, зөрчлийн газарт ажиллах шинжлэн шалгагч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, зөвлөх, ажиглагч нарын эрх нь тухайн албан тушаалтанд холбогдох үнэмлэх олгогдсноор үүсч, буцаж хураалгаснаар дуусгавар болно.

3.3. АХОЗШША болон Хил, хяналтын байгууллагуудын хооронд урьдчилан хамтран ажиллах гэрээ байгуулснаар шинжлэн шалгагчдыг ослын газар, барилга байгууламж, тоног төхөөрөмж, баримт бичгийн газарт нэвтрэх үйл ажиллагааг хурдан шуурхай болгож хөнгөвчилнө.

3.3. Шинжлэн шалгах ажиллагаанд оролцогчид нь шинжлэн шалгах багийн ахлагчийн хяналт дор осол, зөрчлийн бүх талбарт оролцох эрхтэй. Үүнд:

- a) ослын газарт очих;
- b) осолд орсон агаарын хөлгийн үлдэгдлийг шалгах;
- c) гэрчийн мэдүүлэг авах, байцаах;
- d) холбогдох бүх нотлох баримтыг аль болох хурдан авах;
- e) холбогдох бүх баримт бичгийн хуулбарыг авах;
- f) Нислэгийн өгөгдлийн бичлэг тайлж уншихад оролцох;
- g) бүрэлдэхүүн хэсгийн үзлэг, техникийн ярилцлага, туршилт, шалгалт гэх мэт хэргийн газраас гадуурх үйл ажиллагаанд оролцох;
- h) шинжлэн шалгах ажиллагааны явцийн уулзалтын дүн шинжилгээ, олдсон зүйлс, шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлс болон аюулгүй ажиллагааны зөвлөмжийн талаарх хэлэлцүүлэгт оролцох;
- i) шинжлэн шалгах ажиллагааны төрөл бүрийн бүрэлдэхүүн хэсгүүдийн талаар дүгнэлт гаргах;

3.4. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид болон тэдний зөвлөхүүд:

- a) шинжлэн шалгах ажиллагаа явуулж буй улсыг өөрт байгаа холбогдох бүх мэдээллээр хангах
- b) Шинжлэн шалгах ажиллагаа явуулж буй улсын шууд зөвшөөрөлгүйгээр шинжлэн шалгах ажиллагааны явц болон үр дүнгийн талаарх мэдээллийг задруулахгүй байх үүрэгтэй.

## **ДӨРӨВ. БҮРТГЭСЭН УЛС, ОПЕРАТОР УЛС, ЗОХИОН БҮТЭЭСЭН УЛС, ҮЙЛДВЭРЛЭГЧ УЛСЫН ОРОЛЦОО**

4.1. Бүртгэсэн улс, оператор улс, зохион бүтээсэн улс, үйлдвэрлэгч улс бүр шинжлэн шалгах ажиллагаанд итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцуулахаар томилж болно.

4.2. Бүртгэсэн улс болон оператор улс нь итгэмжлэгдсэн төлөөлөгчдөдөө туслах зорилгоор операторын санал болгосноор нэг буюу хэд хэдэн зөвлөхийг томилж болно.

4.2.1 Бүртгэсэн улс болон оператор улсын аль нь ч итгэмжлэгдсэн төлөөлөгч томилоогүй тохиолдолд шинжлэн шалгах ажиллагаа явуулж буй улс нь оператор

улс руу холбогдох дүрэм, журмын дагуу шинжлэн шалгах ажиллагаанд оролцохыг урина.

4.3. Зохион бүтээсэн улс болон үйлдвэрлэгч улс нь агаарын хөлгийн загварын болон эцсийн угсралтыг хариуцсан байгууллагуудын санал болгосноор итгэмжлэгдсэн төлөөлөгчдөдөө туслах зорилгоор нэг буюу хэд хэдэн зөвлөхийг томилж болно.

4.4. Зохион бүтээсэн улс болон үйлдвэрлэгч улсын аль нь ч итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилоогүй тохиолдолд шинжлэн шалгах ажиллагаа явуулж буй улс нь шинжлэн шалгах ажиллагаа явуулж буй улсын журмын дагуу агаарын хөлгийн загвар болон эцсийн угсралт хариуцсан байгууллагуудыг оролцохыг урина.

4.5. Хамгийн их жин нь 2250 кг-аас дээш жинтэй агаарын хөлөгт гарсан ослыг шинжлэн шалгах ажиллагаа явуулж буй улс нь бүртгэсэн улс, оператор улс, зохион бүтээгч улс, үйлдвэрлэгч улс бусад холбогдох улсуудад тус бүрд итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилох хүсэлт явуулна.

## ТАВ. БУСАД УЛСЫН ОРОЛЦОО

5.1. Шинжлэн шалгах ажиллагаанд мэдээлэл, тоног төхөөрөмж мэргэжлийн шинжээчээр оролцож буй аливаа улс нь шинжлэн шалгах ажиллагаанд оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилох эрхтэй.

5.2. Хээрийн шинжлэн шалгах ажиллагааны бааз, эрэн хайх, авран туслах, осолдсон агаарын хөлгийг сэргээх ажиллагаанд оролцож буй аливаа улсыг шинжлэн шалгах ажиллагаанд оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилохоор урьж болно.

5.3. Ослын улмаас иргэд нь хүнд гэмтсэн эсвэл нас барсан улс нь дараах шинжээчийг томилох, оролцох онцгой эрхтэй.

5.3.1. ослын газарт очих;

5.3.2. шинжлэн шалгах ажиллагаа явуулж буй улсаас олон нийтэд мэдээлэхийг зөвшөөрсөн холбогдох баримт мэдээлэл, шинжлэн шалгах ажиллагааны явцын талаарх мэдээлэлтэй танилцах;

5.3.3. эцсийн тайлангийн хуулбарыг авах. Энэ нь тухайн улсын хохирогчдыг таних, амьд үлдсэн хүмүүстэйгээ уулзах, тусламж үзүүлэхэд саад болохгүй.

5.4. Шинжлэн шалгах ажиллагаа явуулж буй улс нь тэдэнд шинжлэн шалгах ажиллагааны эхний жилд тогтоосон бодит мэдээллийг гаргаж, шинжлэн шалгах ажиллагааны явцын талаар цаг тухайд нь мэдээлж байх үүрэг хүлээдэг.

----oO----

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ  
АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБА

НУУЦ ҮЛ ЗАДЛАХ ГЭРЭЭ

Осол, зөрчил: \_\_\_\_\_

Би \_\_\_\_\_, \_\_\_\_\_

шинжлэн шалгах багийн ахлах шинжлэн шалгагчийн зөвшөөрөлгүй дээр дурдсан осол, зөрчлийг шинжлэн шалгахтай холбоотой ямарч мэдээллийг задлахгүй гэдгийг зөвшөөрч байна.

Байгууллага, албан тушаалтантай холбоотой мэдээллүүд, тухайлбал нислэгийн аюулгүй байдалтай шууд холбогдох мэдээлэл, тайлбар, таамаг, яриаг ямар нэгэн хүн болон бусад байгууллагад задлахгүй байх болно.

Миний бие гарын үсэг зурснаар дээрх нөхцлийг уншиж, ойлгосон гэдгээ хүлээн зөвшөөрч баталгаажуулж байгаа юм.

Овог нэр: \_\_\_\_\_

Гарын үсэг: \_\_\_\_\_

Паспортын дугаар: \_\_\_\_\_

Байгууллага: \_\_\_\_\_

Холбоо тогтоох хаяг:

Гар, суурин утас: \_\_\_\_\_


Факсын дугаар: \_\_\_\_\_

Мэйл хаяг: \_\_\_\_\_


Огноо: \_\_\_\_\_

ҮНЭМЛЭХНИЙ ЗАГВАР


1. Шинжлэн шалгагч




2. Итгэмжлэгдсэн төлөөлөгч



3. Зөвлөх



4. Ажиглагч



5. Нөөц шинжлэн шалгагч

